

*Аймгийн ИТХ-ын сонгуульд 4 улс төрийн нам оролцсноос
МАХН, ХҮН –аас сонгуульд мөнгө зарцуулаагүй,
МАН 75.1 сая төгрөг, АН 6.0 сая төгрөг зарцуулсан байна.*



ТӨВ АЙМГИЙН ИТХ- ЫН 2016 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ ЭВСЭЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2016 ОН

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Төв аймгийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Бүлэг 1
Аудитын менежер О.Амаржаргал	Нам, эвсэлийн сонгуулийн зардлын тайлан 5-7
Ахлах аудитор Ц.Базарсад Т.Майцэцэг	Бүлэг 2 Нам, эвсэлийн сонгуулийн хандив..... 8-9
2016 оны 9 дугаар сарын 05-ны өдөр	Дүгнэлт 10 Зөвлөмж 11
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70273204 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу	
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
МУ	Монгол улс
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
МАН	Монгол ардын нам
АН	Ардчилсан нам
МАХН	Монгол ардын хувьсгалт нам
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам
СТХ	Сонгуулийн тухай хууль
СТБ	Сонгуулийн төв байгууллага
ТАХ	Төрийн аудитын тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт , хамарсан хүрээ

Аймгийн ИТХ-ыг сонгох 2016 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэлийн авсан хандив, санхүүжилт болон сонгуулийн зардлын тайланг хянан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Зардлын дүнг хянан нийтэд мэдээлэх,
- Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлах.

Аудитад аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон Нам, эвслийн санхүүгийн баримт материал холбогдох бусад материалууд хамрагдсан болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

Төрийн аудитын тухай хууль

Төсвийн тухай хууль

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Сонгуулийн тухай хууль

Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль, тогтоомжууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Ц.Базарсад, Т.Майцэцэг нар 2016 оны 8-р сарын 25-ноос 10-р сарын 05-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

Нам, эвсэлийн сонгуулийн зардлын тайлан**1.1 Сонгуулийн зохион байгуулалтын талаар**

Сонгуулийн тухай хуулийн хүрээнд 2016 оны орон нутгийн сонгуулийн зохион байгуулалттай холбоотойгоор аймгийн ИТХурлын Тэргүүлэгчид дараах шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

-Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8-д “санал авах өдрөөс 150 хоногийн өмнө аймгийн сонгуулийн тойргийг байгуулна” гэсэн заалтын хүрээнд 2016 оны 1-р сарын 29-ний өдрийн 07 тоот тогтоолоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн тоог 41-ээр, сонгуулийн тойргийн тоог 32 байхаар баталж, тойргийн дугаар, харьяалах нутаг дэвсгэр, тойргийн төвийг тогтоожээ.

-Сонгуулийн тухай хуулийн 152 дугаар зүйлийн 152.1-д заасан хугацаанд буюу ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 4-р сарын 25-ний өдрийн 27 тоот тогтоолоор аймгийн ИТХ-ын сонгуулийн тойргийн мандатын тоог хуваарилан баталж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо, сонгуулийн тойрог, мандатын тооны талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороо, аймгийн сонгуулийн хороонд хүргүүлжээ.

МУ-ын СЕХ-ний 2016 оны 4-р сарын 18-ний өдрийн 21 тоот тогтоолоор УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хороодыг байгуулж, сумдын сонгуулийн хороо байгуулахыг аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосны дагуу сонгуулийн зохион байгуулалтын ажил хийгджээ.

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулсан аймгийн сонгуулийн хороог татан буулгах тухай МУ-ын СЕХ-ний 2016 оны 7-р сарын 07-ний өдрийн 262-р тогтоол гарсан байна. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-хороонд 2016 оны 08-р сарын 03-нд тайлан мэдээгээ тушааж улмаар 2016 оны 08-р сарын 15-ний өдрөөр тасалбар болгон татан буугдсан байна.

1.2 ИТХ-ын сонгуульд оролцсон намуудын сонгуулийн зардлын тайлангийн талаар

Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 57.3-т “Нам, эвсэл нь санал хураалт явагдсан өдрөөс хойш 45 хоногт багтаан зардлын тайлан гаргаж, сонгуулийн төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй” гэж заасан. Төв аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон улс төрийн намууд нь аймгийн Сонгуулийн хороонд зардлын тайлангаа хуулийн хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.

Төв аймгийн ИТХ-ын сонгуульд МАН, АН, МАХН, ХҮН зэрэг дөрвөн улс төрийн нам оролцож МАН 75.2 сая төгрөг, АН 6.0 сая төгрөг зарцуулсан зардлын тайлан, МАХН, ХҮН нь сонгуульд мөнгө зарцуулаагүй мэдэгдэлийг аймгийн Сонгуулийн хороонд ирүүлсэн байна.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “сонгуулийн зардлын тайлан, холбогдох бусад баримт бичгийг хүлээн авсан сонгуулийн байгууллага дараах төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ”, 60.1.2-д “аймаг, нийслэл, сум дүүргийн сонгуулийн байгууллага аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллагад” гэж заасны дагуу аймгийн

Сонгуулийн хороо 2016 оны 8-р сарын 15-ны өдөр дараахь баримт материалыг аймгийн Аудитын газарт ирүүлжээ. Үүнд:

- МАХН-ын аймгийн мянгатын 2016 оны 8-р сарын 16-ний өдрийн №16/39 тоот албан бичгээр ХААН банкинд 5023260886 тоот данстай бөгөөд 2016 оны аймгийн ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагаанд болон намаас нэр дэвшигчдэд санхүүжилт хийгээгүй мэдэгдэл,
- Аймгийн ХҮН-ын 2016 оны 8-р сарын 12-ний өдрийн №32 тоот албан бичгээр 2016 оны УИХ-ын сонгуульд Хөдөлмөрийн үндэсний нам оролцохгүй болсон тул намын Удирдах зөвлөлийн 2016 оны 5-р сарын 04-ний тогтоолоор намын санхүүжилтийг зогсоосон. Аймгийн намын хорооноос аймгийн ИТХ-ын сонгуульд мөнгө зарцуулаагүй мэдэгдэл,
- Аймгийн МАН нь орон нутгийн сонгуулийн зардлын тайланд Тэд-од аудит ХХК-иар аудит хийлгэсэн дүгнэлт, 75180.0 мянган төгрөгийн орлого, 75111.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн сонгуулийн зардлын тайлан, орлогын гүйлгээний дэлгэрэнгүй тайлан, харилцах дансны хуулга, ажил гүйлгээг нотлох анхан шатны баримтыг хавсаргасан намын дарга Ц.Энхбат, нягтлан бодогч А.Гал-Эрдэнэ нарын гарын үсэг зурсан 29 хуудас бүхий баримт,
- Аймгийн АН-ын орон нутгийн сонгуулийн зардлын 6000.0 мянган төгрөгийн орлого, 5980.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ бүхий зардлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайланд Хэрэг эрхлэх газрын дарга Д.Хишигбаяр, нягтлан бодогч Х.Дуламням нар гарын үсэг зурсан 6 хуудас бүхий баримтыг тус тус ирүүлсэн.

Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-д “Орон нутгийн хурлын сонгуулийн тухайд төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон жишигт нийцүүлэн аймаг, нийслэл дэх төрийн аудитын салбар байгууллага нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг санал авах өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө тогтооно” гэж заасны дагуу аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2016 оны 3-р сарын 28-ний өдрийн А/03 тоот тушаалаар аймгийн ИТХ-ын сонгуульд нам, эвсэл тус бүрийн зарцуулах зардлын дээд хэмжээг 166.8 сая төгрөгөөр тогтоож, баталсан. Төв аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон намуудын ирүүлсэн сонгуулийн зардлын тайлангаас үзэхэд батлагдсан сонгуулийн зардлын дээд хэмжээ хэтрээгүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5.1, 43.5.2, 43.5.3-т заасны дагуу Нам нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг дараах төрийн байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй гэж заасны дагуу:

- Аймгийн Сонгуулийн хороонд аймгийн АН нь 2016 оны 5-р сарын 26-ний өдрийн 68 тоот албан бичгээр ХААН банкинд 5130017996 тоот данс нээлгэснийг, МАН нь 2016 оны 4-р сарын 25-ний өдөр 17 тоот албан бичгээр ХААН банкинд 5721583510 тоот данс нээлгэснийг тус тус бүртгэж өгөхийг хүссэн тоот хүргүүлсэн.
- Төв аймгийн Татварын хэлтэст аймгийн АН нь 2016 оны 05-р сарын 26-ний өдрийн 67 тоот албан бичгээр ХААН банкинд 5130017996 тоот данс, МАН нь ХААН банкинд 5721583510 тоот данс нээлгэсэн болохоо мэдэгдсэн.
- Төв аймгийн Аудитын газарт МАН 2016 оны 4-р сарын 25-ний өдөр 18 тоот албан бичгээр ХААН банкинд 5721583510 тоот, АН 2016 оны 5-р сарын 26-ний өдөр 69 тоот албан бичгээр ХААН банкинд 5130017996 тоот данс нээлгэсэн тухайгаа мэдэгдсэн байна.

Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.6-д “Нам, эвслийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш сонгуулийн төв

байгууллагад 45 хоногийн дотор хүргүүлнэ” гэсэн заалт хэрэгжээгүй байна. Мөн хуулийн 57.7-д “57.6-д заасныг зөрчсөн банкны захирлыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан боловч хариуцлагын арга хэмжээг хэн хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 43.3-д “Нам банктай энэ хууль, банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын данс эзэмшигчийн гэрээ байгуулсны үндсэн дээр зардлын данс нээлгэнэ” гэсний дагуу ХААН банктай АН нь 2016 оны 5-р сарын 24-ний өдөр 5130017996 тоот дансыг, МАН нь 2016 оны 4-р сарын 20-ний өдөр 5721583510 тоот дансыг тус тус нээлгэн байгууллагын харилцах данс эзэмшигчийн гэрээг байгуулсан байна. Аймгийн АН-ын харилцах дансны хуулгаарх үлдэгдэл 17.5 мянган төгрөг байгаа нь ХААН банктай харилцах данс нээлгэсэн гэрээний үндсэн нөхцлийн 2.10-д дансанд заавал байлгах доод үлдэгдлийг 20.0 мянган төгрөг гэснийг хангаагүй байна.

Төв аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд 4 улс төрийн нам оролцсноос МАХН, ХҮН-аас сонгуульд мөнгө зарцуулаагүй, МАН 75111.4 мянган төгрөг, АН 6000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төв аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон МАН нь аймгийн сонгуулийн хороонд бүртгүүлсэн ХААН банкны 5721583510 тоот дансыг, АН нь ХААН банкны 5130017796 тоот дансыг ашиглан сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулж хуульд заасан үзүүлэлтээр орон нутгийн сонгуулийн зардлын тайланг гаргаж ирүүлсэн байна.

- МАН-ын сонгуулийн зардлын тайлангаар нам эвсэл, нэр дэвшигчийг сурталчилах зардалд 31640.0 мянган төгрөг, сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардалд 35000.0 мянган төгрөг, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардалд 207.0 мянган төгрөг, шатахуун унааны зардалд 8254.0 мянган төгрөг, банкны үйлчилгээний хөлсөнд 10.4 мянган төгрөг нийт 75111.4 мянган төгрөг зарцуулсан нь холбогдох анхан шатны болон банкны гүйлгээ хийсэн баримтаар нотлогдож байна.
- АН-ын сонгуулийн зардлын тайлангаар нам эвсэл, нэр дэвшигчийг сурталчилах зардалд буюу тугны үнэнд 2980.0 мянган төгрөг, сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардалд 3000.0 мянган төгрөг нийт 5980.0 мянган төгрөг зарцуулснаар тайлан гаргаж ирүүлсэн. Холбогдох нотлох баримт буюу банкны гүйлгээ хийсэн болон анхан шатны баримтыг бүрэн ирүүлээгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Бүлэг 2

Нам, эвсэлийн сонгуулийн хандив

Сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд “сонгуулийн хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байна, хандивлагч нь хуульд заасан шаардлагыг хангасан, Монгол Улсын иргэн байна” гэж заасан.

Төв аймгийн орон нутгийн ИТХ-ын сонгуульд оролцсон улс төрийн намууд нь Сонгуулийн тухай хуулийн 50, 51, 52 дугаар зүйлд заасан шаардлагын хүрээнд хандивын орлогыг бүрдүүлэн зарцуулсан байна.

МАН нь 75180.0 мянган төгрөгийн, АН нь 6000.0 мянган төгрөгийн хандивын орлогыг тайлагнасан байна.

Аймгийн МАН-ын хорооны ирүүлсэн орлогын гүйлгээний дэлгэрэнгүй тайланд 75180.0 мянган төгрөгийн хандивыг тайлагнасан байна. ХААН банкны харилцах дансанд 69 иргэнээс 76280.0 мянган төгрөгийн, 1 банк бус санхүүгийн байгууллагаас 1000.0 мянган төгрөгийн нийт 77280.0 мянган төгрөгийн хандив төвлөрснөөс Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 5.4-д заасан шаардлагыг хангаагүй буюу регистрийн дугааргүй 3 иргэний 2100.0 мянган төгрөгийг буцааж нийт 75180.0 мянган төгрөг тайлагнасан байна.

Аймгийн АН-ын орлогын гүйлгээний тайланд ХААН банкны харилцах дансанд 2 иргэнээс 6000.0 мянган төгрөгийг төвлөрүүлж тайлагнасан нь харилцах дансны хуулгатай тохирч байна.

МУ-ын Сонгуулийн тухай хуулийн 60.3-т “Төрийн аудитын байгууллага зардлын тайланг хянаж, хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана” гэж заасан байна.

Сонгуулийн тухай хуулийн 60.3-д заасны дагуу нийтэд зарлах хандив МАН-д 15 иргэнээс өгсөн 31000.0 мянган төгрөг, АН-д 2 иргэнээс өгсөн 6000.0 мянган төгрөг байна.

Аймгийн МАН-д нийт 75180.0 мянган төгрөгийн хандив төвлөрснөөс сонгуулийн тухай хуулийн 60.3-д заасан буюу нэг сая төгрөгөөс дээш хандив өгсөн нийтэд зарлах нь:

- нэг сая төгрөгийг 6 иргэн,
- хоёр сая төгрөгийг 1 иргэн,
- хоёр сая таван зуун мянган төгрөгийг 2 иргэн,
- гурван сая төгрөгийг 6 иргэн,
- нийт 15 иргэн байна. Эдгээр иргэдээс 31000.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба хоёр сая төгрөгнөөс дээш хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

АН-ын сонгуулийн зардлын дансанд нийт 6000.0 мянган төгрөгийн хандив төвлөрсөн ба сонгуулийн тухай хуулийн 60.3-д заасны дагуу нийтэд мэдээлэх 2 иргэнээс өгсөн 6000.0 мянган төгрөгийн хандив байгаа ба хуулийн этгээдээс өгсөн хандив байхгүй.

Сонгуулийн тухай хуулийн 60.3-д заасан нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэдийн жагсаалт

МАН-д иргэдээс өгсөн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив			/мянган төгрөг/
№	Хандивлагч иргэний эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Хандивын хэмжээ
1	Зоригтбаатар	нс73031571	1,000.0
2	Болдбаатар	ДЮ65122814	1,000.0
3	Д.Шүрэнбат	НЭ59090101	1,000.0
4	Баярхүү	НЭ86112810	1,000.0
5	Г.Эрдэнэбаяр	НД61090274	1,000.0
6	Ц.Эрдэнэбаатар	нг81012073	2,000.0
7	Ж.Батжаргал	ХЛ67110313	2,500.0
8	Б.Жаргалмаа	НТ75101829	2,500.0
9	Ц.Энхбат	НШ65041575	3,000.0
10	Д.Мөнхбаатар	НХ78082611	3,000.0
11	Б.Ганбат	УЖ71052014	3,000.0
12	Б.Цэрэнбат	НА79021976	3,000.0
13	Д.Ганбаяр	НБ57031511	3,000.0
14	Ж.Баттөгс	НТ72100910	3,000.0
15	Ш.Рэнцэндорж	ХЕ58091374	1,000.0
	Дүн		31,000.0
АН-д иргэдээс өгсөн нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив			/мянган төгрөг/
№	Хандивлагч иргэний эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Хандивын хэмжээ
1	С.Энхболд	УХ66091910	3,000.0
2	Л.Батболд	ФД61041213	3,000.0
	Дүн		6,000.0

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Төв аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд 4 улс төрийн нам оролцсноос МАХН, ХҮН-аас сонгуульд мөнгө зарцуулаагүй, МАН 75111.4 мянган төгрөг, АН 6000.0 мянган төгрөг зарцуулсан байна.
2. МАН нь 75180.0 мянган төгрөгийн, АН нь 6000.0 мянган төгрөгийн хандивын орлогыг тайлагнаснаас сонгуулийн тухай хуулийн 60.3-д заасны дагуу нийтэд зарлах хандив МАН-д 15 иргэнээс өгсөн 31000.0 мянган төгрөг, АН-д 2 иргэнээс өгсөн 6000.0 мянган төгрөг байна.
3. Сонгуулийн тухай хуулийн 57.6-д заасны дагуу банкны захирал нь намуудын сонгуулийн зардлын дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайланг аймгийн сонгуулийн хороонд гаргаж ирүүлээгүй байна.
4. АН нь сонгуулийн зардлын тайлангийн зарлагын гүйлгээг нотлох банкны гүйлгээ хийсэн болон анхан шатны баримтыг бүрэн ирүүлээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн:

Төв аймгийн Сонгуулийн хорооны Дарга, Нарийн бичгийн даргад зөвлөх нь:

1. Сонгуулийн тухай хуулийн 57.6-д Нам, эвслийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш сонгуулийн төв байгууллагад 45 хоногийн дотор хүргүүлнэ гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР



Л. ЖАРГАЛСАЙХАН

О.АМАРЖАРГАЛ

Т.МАЙЦЭЦЭГ

Ц.БАЗАРСАД